



НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван Зургадугаар зүйлд “4/ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэж заасан.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль анх 2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр батлагдаж, нийт 17 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Тус хуулийн 4 дүгээр зүйлд 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15-ны өдрүүдэд Үндэсний их баяр наадам-Ардын хувьсгалын ойн баярыг, Цагаан сарыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3-ны өдрүүдэд, Шинэ жилийг 1 дүгээр сарын 1-ний өдөр, Олон улсын эмэгтэйчүүдийн өдрийг 3 дугаар сарын 8-нд, Хүүхдийн баярыг 6 дугаар сарын 1-ний өдөр, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярыг 12 дугаар сарын 29-ний өдөр, Их Эзэн Чингис хааны өдрийг Их Эзэн Чингис хаан мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 1-нд, Бүгд Найрамдах Улс тунхагласан өдрийг 11 дүгээр сарын 26-нд, Бурхан багшийн Их дүйчин өдрийг билгийн тооллын зуны тэргүүн сарын шинийн 15-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэхээр тус тус тогтоосон байна.

Нийтээр амрах баярын өдрүүдийн тухайд 1999 оны 5 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн /энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүйд тооцсон /77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэгт “Нийтээр амрах баярын өдөр, долоо хоног бүрийн амралтын өдөр ойрхон тохиосон тохиолдолд долоо хоногийн ажил, амралтын өдрийг Засгийн газрын шийдвэрээр зохицуулж болно” гэж заасны дагуу тэмдэглэн өнгөрүүлж байсан боловч 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тус зохицуулалт тусгагдаагүй байна.

Өөрөөр хэлбэл, нийтээр амрах баярын өдрүүд нийтээр амрах өдөр буюу амралтын өдөртэй давхацсан тохиолдолд хэзээ тэмдэглэх, уг асуудлыг хэн

шийдвэрлэх нь тодорхойгүй байх бөгөөд тухайн ажил олологчийн зүгээс шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээ мөн хуульд тусгагдаагүй байна.

Иймд Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т заасны дагуу холбогдох хуулийн төсөлд нэмэлт оруулах хуулийн төслийг бэлтгэлээ.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Тодруулбал, Манай улс өргөн уудам газар нутагтаа хэдэн зууны туршид нүүдлийн мал аж ахуй эрхэлж өдийг хүртэл уламжлагдан ирсэн билээ. Энэхүү уламжлалтай уялдуулан Цагаан сарын баярын өдрүүдээр орон нутагт амьдарч буй аав ээж, садан төрлүүддээ очиж золгох, урин дулааны цаг - Үндэсний их баяр наадмаар (аймаг, сум) хүчит бөхийн барилдаан, мэргэн сурын харваа, хурдан морины уралдаан үзэж наадамлах зэрэг цаг хугацаа нэлээдгүй зарцуулах баярын өдрүүд амралтын өдрүүдэд давхацсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх асуудал тодорхойгүй байх тул аж ахуй амьдралдаа нийцсэн зохицуулалтыг хуульд тусгах, эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлага үүсээд байна.

“Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль”-ийн 6 дугаар зүйлд Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх зохицуулалтыг тусгасан байдаг. Харин бүх нийтээр амрах өдөр нь ажлын өдөр таарсан тохиолдолд уг хуулийн зохицуулалт хэрхэн шийдэгдэх эсэх нь ард иргэдийн дунд хүлээлтийг үүсгэж байна. Харин уг хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар Нийтээр амрах баярын өдрүүд ажлын өдөр таарсан тохиолдолд хэрхэх асуудлыг хуулийн зохицуулалтаар шийдвэрлэх ач холбогдолтой юм.

Д/д	4.1.Нийтээр тэмдэглэх баярын өдөр:	Хэзээ тохиох 2025 он	Хэзээ тохиох 2026 он
1	4.1.1.Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15.	2025 оны 7 дугаар сарын 10 - Пүрэв 11 - Баасан 12 - Бямба 13 - Ням 14 - Даваа 15 - Мягмар	2026 оны 7 дугаар сарын 10 - Баасан 11 - Бямба 12 - Ням 13 - Даваа 14 - Мягмар 15 – Лхагва
2	4.1.3.Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3;	2026 оны 2 дугаар сарын 18 буюу Лхагва гараг	
3	4.1.4.Шинэ жил: 1 дүгээр сарын 1;	2025 оны 12 дугаар сарын 31 - Лхагва	2026 оны 12 дугаар сарын 31 - Пүрэв
4	4.1.5.Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр: 3 дугаар сарын 8;	2026 оны 3 дугаар сарын 08 – Ням гараг	

5	4.1.6.Хүүхдийн баяр: 6 дугаар сарын 1.	2025 оны 6 дугаар сарын 01 – Ням гараг	2026 оны 6 дугаар сарын 01 – Даваа гараг
6	4.1.7.Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр: 12 дугаар сарын 29.	2025 оны 12 дугаар сарын 29 – Даваа гараг	2025 оны 12 дугаар сарын 29 – Мягмар гараг
7	4.1.8.Их Эзэн Чингис хааны өдөр: Их Эзэн Чингис хаан мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 1.	2025 оны 11 дүгээр сарын 11 – Мягмар гараг	2026 оны 11 дүгээр сарын 10 – Мягмар гараг
8	4.1.9.Бүгд Найрамдах Улс тунхагласан өдөр: 11 дүгээр сарын 26.	2025 оны 11 дүгээр сарын 26 – Лхагва гараг	2026 оны 11 дүгээр сарын 26 – Пүрэв гариг
9	4.1.10.Бурхан багшийн Их дүйчин өдөр: билгийн тооллын зуны тэргүүн сарын шинийн 15.	2025 оны 06 дугаар сарын 11 - Лхагва гараг	2026 оны 05 дугаар сарын 31 - Ням гараг

Монгол улсын нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд заасны дагуу бид жилд 9 баяраар нийт 16 хоног амарч байна. 2025 оны тухайд эдгээр өдрүүдийн 3 нь Бямба гарагт, 3 нь Ням гарагт тохиож байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү хуулийн төсөл нь 2 зүйлтэй бөгөөд Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 6 дугаар зүйлд нэмэлт оруулахаар зохицуулсан.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан “Монгол Улсын иргэн хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, амрах эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэж заасан эрх хангагдах ач холбогдолтой.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд уг хуулийн төсөлтэй холбогдуулан Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.